



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/1117

Чингис хот

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх
нэгдсэн арга хэмжээ зохион байгуулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1 5, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалтууд, Сангийн сайдын 2018 оны "Засаг даргын нөөц сангийн зарцуулалтын журам батлах тухай" А/318 дугаар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2014 оны "Журам батлах тухай" А-166 дугаар, 2016 оны "Журманд өөрчлөлт оруулах тухай" А/24 дүгээр, 2020 оны "Ойгоос хуш модны самар бэлтгэж ашиглахыг бүсчлэн тогтоох тухай" А/577 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх "Хяналт шалгалт-2020" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад 8875000 /найман сая найман зуун далан таван мянган/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

4. Арга хэмжээнд шаардагдах бусад зардлыг сумын төсөвт тодотголоор суулгаж санхүүжүүлэхийг Батширээт сумын Засаг дарга /М.Бопод/, Өмнөдэлгэр сумын Засаг дарга /Б.Эрдэнэбаатар/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ

201910531

Хяналтын зардал

Д/д	Хяналтын төрөл	Хяналт хийх тоо хэмжээ	шатахууны зардал				томилголын зардал				Хяналтын зардал	
			Нийт явах зай /км/	Нэг машинд зарцуулах	Явах машины	Нийт зарцуулах шатахуун	Нийт зарцуулах шатахууны үнэ	Явах хүний тоо	Нэг өдрийн томилголт	Явах хоног		Нийт томилголын зардал
1	Нэгдсэн хяналт	2	1100	275	2	1100	2750000	10	26500	5	2650000	5400000
	дүн						2750000				2650000	5400000

Бусад зардал

Д/д	Зардлын төрөл	Тоо	Нэг	Нийт дүн
1	Жинлүүр	5	195000	975000
2	Тараах материал	4000	500	2500000
				3475000

Нийт зардал

Д/д	Зардлын төрөл	Мөнгөн дүн
1	Нэгдсэн хяналт	5400000
2	Бусад зардал	3475000
	Дүн	8875000